



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 3 сарын 10 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

### ХI ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XI хурал 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 14:00 цагаас Төрийн ордон дахь Монгол Улсын Шадар сайдын ажлын өрөөнд 96 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Θ.Энхтувшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН нь:

- Коронавируст халдварт (COVID-19)-ын тархалт дэлхий даяар өндөр хурдацтайгаар нэмэгдэж байгаатай холбогдуулан олон улсын бүх нислэг, төмөр замын зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 3 дугаар сарын 28-ны өдрийг дуустал түр зогсоох талаар Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан;
- Хилийн боомтоор нэвтрэх иргэдийн хөдөлгөөнийг 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл түр зогсоох талаар Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн;
- Тусгаарлах байранд болон гэрээр тусгаарлах журмын төслийн тухай Эрүүлмэндийнсайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл;
- Олон улсын нислэг болон төмөр замын зорчигч тээврийг түр зогсоосонтой холбогдуулан гадаад улс орноос эх орондоо буцаж ирэх хүсэлтээ илэрхийлсэн Монгол Улсын иргэдийн тухай Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Улсын онцгой комиссын гишүүн Д.Даваасүрэн;
- Гадаад улс оронд байгаа Монгол Улсын иргэдийг захиалгат нислэгээр эх орондоо татан авчрах тухай Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан;
- Гадаад улс орноос захиалгат нислэгээр татан авчирсан Монгол Улсын иргэдийг тусгаарлах арга хэмжээг зохион байгуулах талаар Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл нарын мэдээллийг сонсов.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Нэг. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,

Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасурэн,

аймгийн Засаг дарга нарт:

1.1. Монгол Улс болон Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Казакстан Улс, Бүгд Найрамдах Турк Улс хоорондын 2 талын хуваарыт нислэг, төмөр замын олон улсын зорчигч тээврийн хөдөлгөөн, Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын авто замын боомтуудаар Оросын Холбооны Улс руу зорчих Монгол Улсын иргэд болон Оросын Холбооны Улсаас Монгол Улс руу зорчин ирэх гадаадын иргэн, харьяалалгүй хүний хөдөлгөөнийг түр зогсоосонтой холбогдуулан зохион байгуулалтын холбогдох арга хэмжээ авч ажиллах;

1.2. Монгол Улс, ОХУ-ын төмөр замын хөлөг ажилтнуудыг улсын хилээр зохих журмын дагуу нэвтрүүлэх;

1.3. Москва-Улаанбаатар чиглэлд 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр аялах 6 дугаар галт тэргийг зорчигчгүйгээр татан авах;

Хоёр.Батлан хамгаалахын сайд,

Улсын онцгой комиссын орлогч дарга Н.Энхболд,

Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Т.Бадрал,

Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал Д.Ганзориг нарт:

2.1. Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Дотоод хэргийн их сургууль, цэргийн зарим анги байгууллагуудыг тусгаарлах байрны зориулалтаар ашиглах бэлтгэлийг хангах;

2.2. Тусгаарлах байранд зарцуулсан зардлыг хянан гамшгийн хор уршгийг арилгах зардлаас санхүүжүүлэх боломжийг судлан танилцуулах;

Гурав. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,

Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан нарт:

3.1. Олон улсын нислэгийг зогсоосонтой холбоотойгоор эх орондоо яаралтай ирэх хүсэлт гаргасан, хүндэтгэн үзэх шалтгаантай Монгол Улсын иргэдийг тээвэрлэн

авчрах зорилгоор Монгол Улс болон ОХУ, ХБНГУ, БНТУ, БНСУ, Япон Улс хооронд захиалгат нислэг гүйцэтгэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

Дөрөв. Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид:

4.1. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Франц Улсын Элчин сайдын яамнаас тавьсан хүсэлтийн дагуу цагдаагийн байгууллагын хамгаалалтыг нэмэгдүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх;

Тав. Онцгой байдлын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Т.Бадралд:

5.1. Монгол Улсад коронавируст халдварын тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханганд ажиллах чиг үүрэг бүхий "Улсын онцгой комиссын шуурхай штаб"-ыг байгуулан ажиллах;

Зургаа. Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж,

Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзориг,

Засгийн газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах

хэлтсийн дарга, Улсын онцгой комиссын гишүүн Ц.Ганзориг,

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Чинбат нарт:

6.1. Мэдээллийг албан ёсны (Засгийн газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс, Эрүүл мэндийн яам) нэг цэгээс өгч байх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр буруу ташаа мэдээлэл түгээсэн тохиолдолд тухайн хэвлэл мэдээллийн байгууллагад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох арга хэмжээ авч ажиллахыг тус тус үүрэг болгов.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,  
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТУВШИН

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТЭРГҮҮН  
ДЭД ДАРГА, БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН